
**Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших
“Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр”-ийн 2024
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1 Төслийн товч танилцуулга.....	3
1.2 Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт.....	4
1.3 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	6
БҮЛЭГ II. ТУХАЙН ЖИЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	8
2.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	8
2.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	9
2.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	10
2.4 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	10
2.3 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	10
2.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	11
2.5 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	12
2.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	14
2.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	15
2.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах.....	15

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч танилцуулга

“Винкапитал” ХХК нь 2012 оны 12 дугаар сард байгуулагдсан цагаас гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаад 2013 оны 12 сараас эхлэн төмрийн хүдэр боловсруулан баяжуулах, чиглэлээр ажиллаж байна.

“Винкапитал” ХХК нь Хэнтий аймгийн Дархан суманд баяжуулах үйлдвэрийг 2013 оны 12 дугаар сард барьж 2014 оны 04-р сард ашиглалтад оруулсан бөгөөд 2 жилийн хуацаанд амжилттай ажиллаж байсан. 2016 оны дундаас тооцоолоогүй шалтгааны улмаас үйлдвэрээ түр хугацаанд зогсоосон. 2018 оны 06 сараас эхлэн шинээр үйлдвэрээ сэргээн засварлан одоог хүртэл амжилттай ажилласан.

Манай компанийн Хэнтий аймгийн Дархан сумын нутагт баригдсан хуурай аргаар баяжуулах үйлдвэр нь 20-30 ажилчин, мэргэжилтэнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 20-30%-тай төмрийн түүхий хүдрийг бутлах, шигших, соронзон сеператороор ялгах дарааллаар баяжуулснаар 48-55%-ийн агуулгатай төмрийн хуурай баяжмал бүтээгдэхүүн гаргадаг. Энэ үйлдвэр нь Хэнтий, Дорноговь аймгийн зааг дээр байршилтай Хэнтий аймгийн Бор-Өндөр сумаас 18 км-т оршдог бөгөөд бусад компанитай гэрээ хийж төмрийн хүдрийг нь баяжуулж өгдөг.

Үйлдвэрийн эзэмшил талбайн хэмжээ 20 га.

Хуурай баяжуулах үйлдвэр нь жилд 200,000-250,000 тн түүхий хүдрийг баяжуулж 110,000-137,500 тн хуурай баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай.

2024 онд ...





Зураг 1. Үйлдвэрийн харагдах байдал

1.2 Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

Уур амьсгал

Баргилт –Овоогийн төмрийн хүдрийн ордыг түшиглэн байгуулах хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэр орчмын нутаг дэвсгэрийн нарны цацрагийн жилийн явцаас хамааран сэрүүн бүсэд жилийн дөрвөн улирал ээлжилдэг. Тухайн орон нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын шинж зэргээс хамааран улирлын шинж газар бүр харилцан адилгүй байна.

Хөрсөн бүрхэвч

Судалгааны талбайн Монгол орны хөрс- газарзүйн мужлалаар Хангайн их муж, хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүс, Бор Өндөр –Уул буяны тойрогт хамаарагдана. Төслийн талбайн районд толгодын нимгэн сайрчулуурхаг хүрэн хөрс тархана энэхүү хөрс нь далайн түвшнээс дээш 1481-1501м –ийн өндөрт байрласан нам уулс толгод, тэгш талд тогтворжсон байна. Гадаргын налуу буюу хэвгий 0.83-5.3 градус байна.

Ургамлан нөмрөг

Ургамал-газар зүйн мужлалаар А.А,Юнатовын үйлдсэн ботаник газарзүйн мужлалаар Евро-Азийн хээрийн мужийн Дагуур-Монголын хээрийн хошууны Дундад Халхын хээрийн тойрогт хамаарна. Тухайн тойрог ухаа гүвээт толгод бүхий тэгш талын төрхтэй. Тэнд хээрийн ургамалжилт зонхилж хотос хонхор газраар нь дэрс бүхий давсаг (галофит) ургамалт бүлгэмдэл элбэг тааралдана. Бор-Өндөр орчмын нутаг гол төлөв хээрийн хэвшинжийн ургамалжилт зонхилох бөгөөд хэд хэдэн дэд хэвшинжид ангилагдана.

Нийгэм

Энэ нутагт халх ястан голлон амьдарна. Хүн амын нягтаршил багатай, Дархан сум нь 1956 оны 8-р сарын 1-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Баянмөнх сумтай нийлж, 1957 оны 8-р сарын 1-нд дахин бие даасан сум болон байгуулагджээ. Одоо Дархан сум нь засаг захиргааны 5 багтай, 2000 орчим хүн амтай, 189759 толгой малтай байна.

1.3 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Байгаль экосистемийн өөрчлөлт: Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар боловсруулах үйлдвэрийн хэсэг, хаягдал хүдрийн овоолго, хаягдлын овоолго, ажилчдын суурин байгууламж барих зэргээр хөрсний хэв шинж болон ургамлын төрөл зүйл, байгалийн тогтоц өөрчлөгдөнө.

Мөн төслийн үйл ажиллагааны бүх үе шатнаас хөрсөн бүрхэвчид сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Үүнд:

- Үйлдвэрлэлийн барилга, газар шорооны ажил
- Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал, түүнийг хуримтлуулах байгууламж
- Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн
- Машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдах үед хөрсөнд шатах тослох материал асгарах зэргээс хөрс бохирдох магадлалтай юм.

Байгалийн баялаг, нөөц ашиглалт: Үйлдвэрийн үндсэн зорилго нь байгалийн баялгийг ашиглахад чиглэсэн бөгөөд нөлөөлөл нь мөн шууд, буцалтгүй шинжтэй байна. Иймд Монгол Улсын ашигт малтмалын хууль, байгаль хамгаалах хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, байгалийн баялгийг алдагдал хаягдалгүй бүрэн ашиглах, байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг жил бүр үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлж байх үүрэгтэй.

Байгаль орчны чанарын өөрчлөлт:

Усан орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл: Төсөл нь технологи үйл ажиллагаанд ус ашиглахгүй тул гүний болон гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл маш бага. Харин төсөлд ашиглах технологи, техник хэрэгслийг буруу сонгосноос сөрөг нөлөөллүүд бий болох магадлалтай байна Үүнд:

- Төсөлд ашиглах техник хэрэгслийн шатах тослох материалын хаягдлыг зориулалтын дагуу устгаагүйгээс хөрсөнд нэвтрэх, улмаар гүний ус бохирдох нөхцөл үүсэх
- Ахуйн хэрэглээнд усыг ариг гамгүй ашигласнаар усны нөөц хомсдох

Агаарын чанарт үзүүлж болзошгүй нөлөөлөл: Төслийн зүгээс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь үйлдвэрийн бутлах, шигших, ялгах үйл ажиллагааны үед үүсэх тоосжилт, мөн төмрийн хүдрийг ачих, буулгахад үүсэх тоосжилт юм. Үүнд:

- Хөрс хуулах, ачих буулгах болон тээвэрлэлтийн үед тоосжилт үүсэх

- Төмрийн хүдэр боловсруулах үйлдвэрээс ялгарах тоос нь агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлнэ
- Ажилчдын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын үнэр
- Хөрс хуулалт, хүдэр тээвэрлэлт буулгалт, технологи ажиллагаа-бутлалт зэргээс дуу чимээ, доргио чичиргээ бий болох

БҮЛЭГ II. ТУХАЙН ЖИЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан 2019 оны А/168 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг үндэслэл болголоо.

Байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх
- Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд 5.06 төг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах аргазүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

2.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Агаар бохирдох	Машин техникийг үзлэг оношилгоонд оруулах	Үйлдвэрт ажиллаж буй бүх автомашинууд	Жилд 1 удаа	-	-	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль; Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2008 Бензин хөдөлгүүртэй авто машин-Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2009 Дизель хөдөлгүүртэй авто машин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009
Тоосжилтоор агаар бохирдох	Одоогийн хийсэн байгаа хог хаягдал түр хадгалах цэгийн доорх талбайг бүрэн битүүмжлэн хатуу хучилттай болгож, ирмэг хөвөө бүхий хүрээтэйгээр хийх	Хогийн цэг	Хавар	100.0		
Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол бий болох	Автомашинуудын засвар үйлчилгээг зөвхөн хатуу хучилттай талбайд гүйцэтгэх	Бүх автомашин, техник хэрэгсэл	тогтмол	-	-	Газрын тухай хуулийн 50-р зүйл 50.1.1 дэх заалт. MNS 5924:2015 "Нүхэн жорлон, угаадасны нүх, Техникийн шаардлага
	Одоогийн нүхэн жорлонг MNS 5924:2015 стандартын дагуу доторлох	Бие засах газар	2-р улирал	-	1000.0	
	Үйлдвэрийн талбайд байгаа төмөр, дугуйны хаягдлыг хаягдал дахин боловсруулах үйлдвэрт тушаах	Ажиллагсад ил задгай хог хаягдал хаяхгүй байхыг хэвшүүлэх	тогтмол	Дотоод төлөвлөлтөөр		
	Шатахуун түгээгүүрийн доорх талбайг хатуу хучилттай болгох	Зам талбайг хатуу хучилттай болгох	2-р улирал	-	20.0	
Сөрөг нөлөөллийг бууруулах ажлын нийт зардал сая.төг					1120.0	

2.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үйлдвэрийн хашааны хойд ханыг дагуулан зурвас байдлаар улиас, хайлаас мод тариалах	ш	500	1500.0	4-5, 9-10 сар	MNS 5914:2008 MNS 5915:2008 MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
2	Ажилчдын байр орчимд цэцгийн мандал байгуулах	м ²	100	50.0	5-6 сар	
3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутагт мод тариалах	ш	250	500.0	Хавар, намар	
	Нийт зардал, мян.төг			2050.0		

2.4 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн олборлолтод өртөж эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх	Орон нутгаас зааж өгсөн хаягдсан газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх	га	Орон нутагтай харилцан тохиролцсоны дагуу	Ажлын хэмжээнээс хамаарна.	2024 он	MNS 5914:2008 MNS 5915:2008 MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008

2.3 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Үйлдвэрийн талбайн орчимд одоогоор түүх соёлын олдвор олноогүй. Хэрэв түүх соёлын дурсгалт зүйлс, археологи, палентологийн олдвор илэрсэн тохиолдолд сум, аймгийн захиргаанд болон мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэж зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулна.

2.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Гол болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Давтамж	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт
Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах	Бүх ажилчдад байгаль хамгаалах талаар сургалт орох - Компанийн байгаль орчны талаар баримталж буй бодлого, хууль эрхзүй - Бидний үйл ажиллагаа БО-д хэрхэн нөлөөлдөг вэ? - БО-д ээлтэй байхын тулд би юу хийж чадах вэ? - Шатах тослох материал болон химийн бодисын асгаралт, түүнээс урьдчилан сэргийлэх тухай - Ахуйн болон аюултай хог хаягдлыг ангилан ялгах, тэмдэг тэмдэглэгээг таниулах, зөв дадал өгөхөд чиглэсэн сургалт явуулах	жилд 1 удаа	-	Гамшгаас хамгаалах тухай хууль
Үйлдвэрийн үйл ажиллагаанаас ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Нийт ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Жилд 1 удаа	Дотоод төлөвлөгөөг өөр	Эрүүл мэндийн тухай хууль
	Ажилчдад анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх эмийн санг бэлэн байлгах, нөхөж хийх	Жилд 2 удаа	200.0	
Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах	самбар, зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээ байршуулах гал унтраах хор авах	100.0	MNS85078-2001, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага” 5390:2004, “ХААЭА. Цахилгааныг ажлын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
	Ажиллагсдыг цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаанд сургаж, гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулах	сургалт, жилд 1 удаа		
	Шатахууны агуулахын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, асгаралт явагдаж байгаа эсэхийг	тогтмол		

	хянах, тодорхой ажилтанд хариуцуулна.		
Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа	Тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан тогтмол хийж, техникийн ашиглалтын паспортад тэмдэглэдэг байх	Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт	-
Нийт зардал			300.0

2.5 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Бүх хог хаягдал	Үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах - Төмрийн хаягдал - Цаасны хог хаягдал - Гялгар уутны хаягдал - Хуванцар хаягдал - Модны хаягдал - Хоол хүнсний хаягдал - Шил, лааз - Бусад	Бүх хог хаягдал	-	-	-	-	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
Энгийн Энгийн хог хаягдал	Шаардлагатай газруудад доорх цаас, хуванцар сав, тостой хаягдал, бусад г.м ангилал бүхий хогийн савнууд байрлуулах	Засварын газар, ажилчдын байр	ш	125.0	2	250.0	2-р улирал	Хог хаягдлын тухай хууль
	Энгийн хог хаягдлыг сумын ТҮК-ээр зайлуулах /гэрээ сунгах/	Хөрс бохирдох	тн	-	-	Гэрээний дагуу	Жил бүр гэрээг сунгах	Хог хаягдлын тухай хууль MNS 5344:2011
	Ахуйн хог хаягдлын бункерт ямар төрлийн хог хаягдал	Хог хаягдал ангилан хаях	ш	4	-	-	4 сар	Хог хаягдлын тухай хууль

	хийх тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах							
Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлыг холбогдох журмын дагуу тус бүрд нь ангилж хадгалах - Тостой даавуу - Тостой сав, баглаа боодол - Шатах тослох материалын хаягдал - Тосны шүүр - Хаягдал баттерей - Аккумулятор г.м	Аюултай хог хаягдал	бүх	-	-	Гэрээний дагуу	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль Засгийн газрын 116-р тогтоол
	Ашигласан тос, тосолгооны материал, тостой даавуу гэх мэт аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар устгуулах	Хөрс бохирдуулах	-	-	-	Ахуй мандал ХХК-тай байгуулсан гэрээний дагуу төлөх	Тогтмол	
	Хаягдал аккумуляторыг 2-догч түүхий эд авах цэгт тушаах	Хаягдал аккумулятор	ш	Үлэмж хүдэр ХХК-д			Жил бүр	
	Одоогоор хаягдал тосны шүүр боловсруулах үйлдвэр байхгүй тул өөрийн талбайд хууль, журмын шаардлага хангасан байгууламжид түр хадгалах	Хөрс бохирдох	ш	Өөрийн талбайд			Тогтмол	
	Хаягдал дугуйг 2-догч түүхий эд авах цэгт тушаах, тушаах боломжгүйг холбогдох журмын шаардлага хангасан нөхцөлд өөрийн талбайд түр хадгалах	Хаягдал дугуй		Жижиг дугуйг “Инахис” ХХК-д нийлүүлэх, том хэмжээтэйг өөрийн талбайд хадгалах			Жил бүр	
	Хаягдал батерейг УБ хотод Цэнгэг усны төвд өгөх	Бүх батерей	ш	-	-	Батарейг Цэнгэг усны төвд	Жил бүр	
Нийт, мян.төг						250.0		

2.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал мян.төг	Зардал, мян.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
1. АГААРЫН ЧАНАР					
Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос PM _{2.5} , PM ₁₀ Тоосны уналт Бохирдлын цэгэн эх үүсвэр: SO _x , NO _x CO, дуу чимээ	<ul style="list-style-type: none"> Баяжуулах үйлдвэр Ажилчдын байр Үйлдвэрийн салхины чиглэлээс доош 300м, 600м зайд 	Улирал бүр. Жилд 4 удаа	35.0	560.0	Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага: MNS 4585:2007 MNS 3384-82. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4585-98. Агаар орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 12.055-91. Ажлын байрны агаар дахь тоосны хэмжээг тодорхойлох
2. ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УС					
Усны ерөнхий химийн шинжилгээ, хүнд металл	<ul style="list-style-type: none"> Гүний худаг 	Жилд 1 удаа	46.0	46.0	Усны тухай хууль 2012.05.17 Ундны усны чанарын стандарт MNS 900:2018
3. ХӨРСӨН БҮРХЭВЧ					
Хөрсний агрохими, хүнд металл	<ul style="list-style-type: none"> Баяжуулах үйлдвэрийн хашаан дотор Хогийн цэг Үйлдвэрээс зүүн урагш салхины чиглэлээс доош 300м, 600м зайд 	Жилд 2 удаа	70.0	560.0	Дээжлэлт хийхдээ MNS:3297:1991 MNS 3473:1983 MNS 4288:1995 MNS 5850:2008
Нэг жилийн орчны хяналт шинжилгээний зардал, мян.төг					1166.0

2.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		Сар		
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж БОАЖЯ-аар батлуулах	-	1 улирал	Менежер	БОНБУ-ий тухай хууль
Ус ашиглуулах дүгнэлтийг Хэнтий аймгийн байгаль орчны газраар гаргуулах	50	Жил бүр 1 улирал	Менежер	Усны тухай хууль
Сумын ЗДТГ-тай Ус ашиглах гэрээ байгуулах, эрхийн бичиг сунгуулах	50	Жил бүр 1 улирал	Захирал	Усны тухай хууль
Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагтай хамтран ажиллах, харилцан тохиролцож тэдний санал хүсэлтийг шийдвэрлэх	-	Жил бүр	Захирал	Нийгмийн хариуцлага
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу Байгаль орчны аудит хийлгэх	-	2024	Захирал	БОНБУ-ийн тухай хууль
Нийт зардал, мян.төг	100.0			
5 жилд, мян.төг	100.0			

2.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Хугацаа	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
Төслийн талбайн ойролцоох иргэд болон төсөл хэрэгжиж буй баг, сонирхогч талууд, засаг захиргааны ажилчид	Цаасан болон presentation хэлбэрээр тайлагнах, хэлэлцэх	Үйл ажиллагааны талаарх мэдээлэл, төслөөс БО болон нийгэм эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах багасгах чиглэлээр хийсэн арга хэмжээ, байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажлын тухай	10 сард	50.0	Захирал, менежер	Төсөл хэрэгжиж буй баг

БОМТ-ий биелэлтийн тайланг нийслэлийн БО-ы газраар дүгнүүлэх	4% хэвлэмэл болон цахим хэлбэрээр	Тухайн жилийн БОМТ-ий хүрээнд, мөн байгаль хамгаалах чиглэлээр хийсэн нэмэлт ажлуудын тухай	11 дүгээр сарын 1	-	Захирал, менежер	Аймгийн БОГ
Нийт зардал, мян.төг				-		
5 жилд, мян.төг				50.0		

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 5036.0 мян.төг зарцуулахаар байна. Үүнд:

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ - 1.12 сая.төг
- Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө – 2.05 сая.төг
- Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө- 0.3 сая.төг
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө- 0.25 сая.төг
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр- 1.16 сая.төг
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах – 50.0 мян.төг
- Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө – 100.0 мян.төг